



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Батширээт сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан.

Аудитын код: ХЭА-2026/008/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот

2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар

Утас: 70562112

Цахим хаяг: khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа

Утас: 99775390

Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитор: Х.Еркегүл

Утас: 99040705

Цахим хаяг: erkegulkh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	12
3.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил, шийдвэрлэлт. ....	12
3.1.1 Төлбөрийн акт.....	12
3.1.2 Албан шаардлага .....	12
3.1.3 Зөвлөмж .....	12
3.2 Тус сумын харьяа орон нутгийн болон улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил, шийдвэрлэлт .....	13
3.2.1 Орон нутгийн байгууллагуудад илэрсэн алдаа зөрчил, шийдвэрлэлт .....	13
3.2.2 Улсын төсвийн байгууллагуудад илэрсэн алдаа зөрчил, шийдвэрлэлт .....	13
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	15

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОХНСАХЗ	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв.

---



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗАР**

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,  
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,  
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.03.25 № 501

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН БАТШИРЭЭТ  
СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Б.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Батширээт сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийт 281.5 сая төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж дангаараа буюу нийт дүнгээрээ материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- ✓ Орон нутгийн төсвийг төлөвлөхдөө урьд оны үлдэгдлийг нийт 22.0 сая төгрөгөөр дутуу төлөвлөж төсвийн орлогын эх үүсвэрийг бүрэн дайчлаагүй;
- ✓ Орон нутгийн төсвийн орлогыг үндэслэлтэй төлөвлөж, биелэлтэд хяналт тавьж ажиллаагүйгээс үл хөдлөх хөрөнгийн албан татвар, хөрөнгө борлуулсны орлого, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, торгуулийн орлого зэрэг нийт 5 төрлийн орлогыг 8.5 сая төгрөгөөр дутуу бүрдүүлсэн;
- ✓ Сумын ИТХ-аар батлагдсан төсвийн санхүүжилтийг засаг даргын тамгын газарт 25.2 сая төгрөгөөр илүү олгосон;
- ✓ Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний гүйцэтгэлийг төлөвлөсөн болон гэрээнд заасан

- хугацаанд хүлээж авдаггүй, гүйцэтгэлд хяналт тавьж хэрэгжилтийг тооцдоггүй он дамжуулан урьдчилж төлсөн зардлаар бүртгэдэг;
- ✓ ЗДТГ-ын төсвөөс олон нийтийн цагдаагийн ажилтанд урамшуулал 5.0 сая төгрөг, сонгуулийн үр дүнгээр албан тушаалаасаа чөлөөлөгдсний нэг удаагийн тэтгэмжид 11.2 сая төгрөгийг тус тус үндэслэлгүй олгосон;
  - ✓ Батширээт тохижилт ОНӨААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж ажиллаагүй, нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандартын дагуу хөтлөөгүй, 22.0 сая төгрөгөөр үндсэн хөрөнгө худалдаж авсан боловч бүртгэлд тусгаагүй, Ачааны авто машиныг байгууллагын нэр дээр шилжүүлээгүй, шилэн дансны цахим системд байгууллагыг бүртгүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 37 дугаар зүйлийн 37.1.8-д “төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох”, 41 дүгээр зүйлийн 41.2.5-д “энэ хуулийн 37.1.8-д заасан эрхийн хүрээнд төсвийн байгууллагын зардлыг санхүүжүүлэх”, 57 дугаар зүйлийн 57.3-т “Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна”,

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1-д “Аймаг, сум, нийслэл, дүүргийн Хурлын дарга болон бүх шатны Засаг дарга ээлжит сонгуулийн дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бол тэдгээрт урьд нь эрхэлж байсан албан тушаалын зургаан сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно.”

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”;

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-д “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөр, 24 арга хэмжээг санхүүжүүлэхээр татварын болон татварын бус орлогоор 842.5 сая төгрөг, аймгийн төсвөөс санхүүгийн дэмжлэгээр 1,343,7 сая төгрөг, аймгаас орон нутгийн хөгжлийн санд олгох санхүүгийн дэмжлэгээр 358.8 сая төгрөг, урьд оны эхний үлдэгдлээс 1,942.0 сая төгрөг, малын тоо толгойн албан татвараар 30.0 сая төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 10.0 сая төгрөг, зээлийн эргэн төлөлтөөр 41.0 сая төгрөг, нийт 4,568.0 сая төгрөгийн төсөв батлагдснаас, үйл ажиллагаандаа 3,660.1 сая төгрөгийг зарцуулж, 80.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

### **Аудитын гол асуудал**

Батширээт сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 389.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч 107.5 сая төгрөгийн алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, 8.5 сая төгрөгийн зөрчилд

1 зөвлөмж өгч, 261.8 сая төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага хүргүүлж, 11.2 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоов.

Орон нутгийн төсөвт 842.5 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 1,505.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг нийт дүнгээр 94.6 сая төгрөгөөр буюу 73 хувиар давуулан биелүүлсэн боловч татварын төрлөөр авч үзвэл 5 төрлийн татвар 8.5 сая төгрөгөөр дутуу биелсэн байна.

Даваж биелсэн татварын дийлэнх хувийг цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, ойн нөөц ашигласны төлбөр, улсын тэмдэгтийн хураамж, бусад орлого эзэлж байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

### **Бусад асуудлын хэсэг**

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, 54.5 дахь заалтын дагуу бэлтгэж ирүүлэх үүрэгтэй боловч 54.5.4-д “Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/” гэж заасны дагуу тайланг бэлтгэж ирүүлээгүй байна. Иймд дараагийн аудитад санхүүгийн тайлангийн иж бүрдлийг бүрэн бэлтгэж ирүүлэх шаардлагатай байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэгжүүлэх эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(Мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>2,695,131.96</b>	<b>2,590,023.44</b>
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	2,112,013.64	1,733,622.09
3	1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	312,285.09	281,759.56
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	7а, 7б	109,615.94	281,289.69
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	152,687.29	274,566.11
6	1.1.6 НӨӨЦИЙН БАРАА	9а	8,530.00	18,786.00
<b>7</b>	<b>1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>3,315,885.72</b>	<b>3,763,463.88</b>
8	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	3,315,885.72	3,763,463.88
9	1.2.2.02 Биет хөрөнгө		3,042,298.92	3,489,877.08
10	1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	273,586.8	273,586.8
<b>11</b>	<b>1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>		<b>6,011,017.67</b>	<b>6,353,487.32</b>
<b>12</b>	<b>2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		<b>5,453.84</b>	<b>5,885.93</b>
13	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		5,453.84	5,885.93
14	2.1.1.03 Өглөг		5,453.84	5,885.93
<b>15</b>	<b>2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		<b>6,005,563.83</b>	<b>6,347,601.39</b>
16	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		6,005,563.83	6,347,601.39
17	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		666,828.14	666,828.14
18	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		5,013,716.18	5,355,753.74
19	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		325,019.52	325,019.52
<b>20</b>	<b>2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>		<b>6,011,017.67</b>	<b>6,353,487.32</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(Мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Тодруу лга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>		<b>5,589,755.52</b>	<b>4,274,411.21</b>
2	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО		1,111,259.7	1,378,600.05
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар		475,392.71	474,463.61
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		475,392.71	474,463.61
5	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		52,570.39	60,763.92
6	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		583,296.6	843,372.52
7	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	2,572,051.67	2,895,811.16
8	1.1.1.04.3 Тусламжийн орлого		0.00	1,519,813.46
9	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,906,444.14	0.00
<b>10</b>	<b>1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2а, 2б</b>	<b>3,003,996.67</b>	<b>3,582,981.16</b>
11	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ		3,003,996.67	3,582,981.16
12	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,914,373.52	3,415,429.57
13	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		920,872.42	1,072,191.35
14	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		115,684.02	129,428.62
15	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		570,736.18	602,903.16
16	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		62,092.94	77,994.34
17	1.1.2.01.1.05 Нормативт зардал		12.00	2,105.50
18	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		85,265.76	173,423.73
19	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал		34,522.00	52,972.00
20	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		755,203.41	666,582.49
21	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		369,984.78	637,828.38
22	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		89,623.15	167,551.59
<b>23</b>	<b>1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>		<b>2,585,758.85</b>	<b>691,430.05</b>
24	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		601,241.88	349,392.49
25	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		-601,241.88	-349,392.49
<b>26</b>	<b>1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)</b>		<b>1,984,516.97</b>	<b>342,037.56</b>

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө / өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,010,746.95		4,010,746.95
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,803.01		1,803.01
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,012,549.97		4,012,549.97
4	1.1.1.1.2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-1,943.10		-1,943.10
5	1.1.1.1.3 Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	10,440.00		10,440.00
6	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	1,984,516.97		1,984,516.97
7	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,005,563.83		6,005,563.83
8	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	6,005,563.83		6,005,563.83
9	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,005,563.83		6,005,563.83
10	1.7 Тайлант үеийн үр дүн	342,037.56		342,037.56
11	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	6,347,601.39		6,347,601.39

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	<b>6,650,481.50</b>	<b>4,501,884.35</b>
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	<b>1,111,259.70</b>	<b>1,378,600.05</b>
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	475,392.71	474,463.61
4	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	52,570.39	60,763.92
5	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	583,296.6	843,372.52
6	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	24,333.53	62,840.71
7	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	18,296.09	14,697.13
8	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	540,666.97	765,834.68
9	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<b>1,102,490.51</b>	<b>3,123,284.30</b>
10	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	1,102,490.51	472,324.32
11	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.00	2,292,135.08
12	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.00	358,824.90
13	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<b>4,436,731.29</b>	<b>0.00</b>
14	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	<b>5,113,924.26</b>	<b>3,950,620.07</b>
15	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	<b>5,113,924.26</b>	<b>3,950,620.07</b>
16	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<b>5,014,839.31</b>	<b>3,773,792.06</b>
17	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	943,363.23	1,098,238.72
18	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	131,809.10	128,966.18
19	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	563,983.78	605,950.90
20	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	66,998.72	182,525.53
21	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	0.00	2,864.00
22	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	93,004.66	185,642.61
23	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	32,142.00	48,192.00
24	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	569,244.26	649,933.03
25	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	2,614,293.55	871,479.09
26	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	<b>99,084.96</b>	<b>176,828.01</b>
27	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	<b>1,536,557.23</b>	<b>551,264.28</b>
28	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	<b>859,709.43</b>	<b>929,655.83</b>
29	1.1.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	859,709.43	929,655.83
30	1.1.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	859,709.43	929,655.83
31	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	<b>-859,709.43</b>	<b>-929,655.83</b>
32	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	<b>99,000.00</b>	<b>0.00</b>
33	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	<b>-99,000.00</b>	<b>0.00</b>
34	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	<b>577,847.8</b>	<b>-378,391.55</b>
35	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	<b>1,534,165.84</b>	<b>2,112,013.64</b>
36	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<b>2,112,013.64</b>	<b>1,733,622.09</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	<b>2,626,045.60</b>	<b>3,273,455.72</b>
2	3.1.01.1.1 Татварын орлого	<b>863,510.00</b>	<b>1,378,600.05</b>
3	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	418,200.00	474,463.61
4	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	418,200.00	474,463.61
5	3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	290,000.00	315,014.58
6	3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого	80,000.00	100,065.65
7	3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого	45,000.00	58,553.39
8	3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого	3,200.00	830.00
9	3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар	50,510.00	60,763.92
10	3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	18,000.00	14,863.58
11	3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар	2,510.00	2,356
12	3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар	30,000.00	43,544.33
13	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	394,800.00	843,372.52
14	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	17,000.00	62,840.71
15	3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгтийн хураамж	9,000.00	55,073.03
16	3.1.01.1.1.8.1.06 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1,500.00	720.00
17	3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж	6,500.00	7,047.68
18	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	12,000.00	14,697.13
19	3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр	12,000.00	14,697.13
20	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	365,800.00	765,834.68
21	3.1.01.1.1.8.3.01 Ойн нөөц ашигласны төлбөр	321,300.00	720,891.88
22	3.1.01.1.1.8.3.02 Ан амьтны нөөц ашигласны төлбөр	44,500.00	44,942.80
<b>23</b>	<b>3.1.01.1.2 Татварын бус орлого</b>	<b>1,762,535.60</b>	<b>1,894,855.67</b>
24	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	60,000.00	192,320.07
25	3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого	8,000.00	5,955.00
26	3.1.01.1.2.1.4 Төсөв байгууллагын өөрийн орлого / үндсэн/	41,000.00	54,869.72
27	3.1.01.1.2.1.5 Төсөв байгууллагын өөрийн орлого / туслах/	10,000.00	10,535.00
28	3.1.01.1.2.1.9 Бусад орлого	1,000.00	120,960.35
29	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	1,343,710.70	1,343,710.70
30	3.1.01.1.2.3.3 Аймаг нийслэлээс авсан татаас	1,343,710.70	1,343,710.70
31	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	358,824.90	358,824.90
32	3.1.01.1.2.4.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	358,824.90	358,824.90
<b>33</b>	<b>3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,567,990.30</b>	<b>5,499,056.13</b>
<b>34</b>	<b>3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,355,665.40</b>	<b>4,624,868.60</b>
<b>35</b>	<b>3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,297,391.20</b>	<b>2,736,710.90</b>
36	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,204,179.70	1,014,760.37
37	3.1.01.2.1.1.1.01 Үндсэн цалин	509,705.90	534,513.81
38	3.1.01.2.1.1.1.02 Нэмэгдэл	530,393.80	375,345.28
39	3.1.01.2.1.1.1.03 Унаа хоолны хөнгөлөлт	63,000.00	39,374.32
40	3.1.01.2.1.1.1.04 Урамшуулал	35,080.00	21,028.09
41	3.1.01.2.1.1.1.05 Гэрээт ажлын хөлс	66,000.00	44,498.86
42	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	150,522.60	128,966.18
43	3.1.01.2.1.1.2.01 Тэтгэврийн даатгал	102,355.40	88,127.45
44	3.1.01.2.1.1.2.02 Тэтгэмжийн даатгал	12,041.80	10,225.48
45	3.1.01.2.1.1.2.03 ҮОМШӨ-ний даатгал	6,020.90	5,047.65
46	3.1.01.2.1.1.2.04 Ажилгүйдлийн даатгал	6,020.90	5,047.65
47	3.1.01.2.1.1.2.05 Эрүүл мэндийн даатгал	24,083.60	20,517.94

48	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	687,084.60	605,881.00
49	3.1.01.2.1.1.3.01 Гэрэл, цахилгаан	86,396.10	67,354.80
50	3.1.01.2.1.1.3.02 Түлш, халаалт	576,155.50	516,910.26
51	3.1.01.2.1.1.3.03 Цэвэр, бохир ус	24,533.00	21,615.94
52	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	71,927.00	50,603.02
53	3.1.01.2.1.1.4.01 Бичиг хэрэг	7,178.90	4,519.30
54	3.1.01.2.1.1.4.02 Тээвэр, шатахуун	50,432.00	37,697.44
55	3.1.01.2.1.1.4.03 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,843.80	3,385.58
56	3.1.01.2.1.1.4.05 Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,384.50	120.00
57	3.1.01.2.1.1.4.06 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,087.80	4,880.70
58	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	8,250.00	2,864.00
59	3.1.01.2.1.1.5.03 Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,250.00	2,864.00
60	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	265,334.80	221,110.91
61	3.1.01.2.1.1.6.01 Багаж, техник, хэрэгсэл	100,414.80	71,433.39
62	3.1.01.2.1.1.6.03 Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	15,000.00	13,128.19
63	3.1.01.2.1.1.6.04 Урсгал засвар	149,920.00	136,549.34
64	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	57,229.00	48,192.00
65	3.1.01.2.1.1.7.02 Дотоод албан томилолт	57,229.00	48,192.00
66	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	712,383.20	570,219.09
67	3.1.01.2.1.1.8.01 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	703,753.10	566,925.16
68	3.1.01.2.1.1.8.02 Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,549.70	588.00
69	3.1.01.2.1.1.8.03 Даатгалын үйлчилгээ	1,267.30	621.96
70	3.1.01.2.1.1.8.04 Тээврийн хэрэгслийн татвар	746.40	538.25
71	3.1.01.2.1.1.8.05 Тээврийн хэрэгслийн оношлогоо	322.60	198.00
72	3.1.01.2.1.1.8.06 Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,695.40	900.00
73	3.1.01.2.1.1.8.07 Газрын төлбөр	1,048.70	447.72
74	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	140,480.30	94,114.35
75	3.1.01.2.1.1.9.01 Бараа үйлчилгээний бусад зардал	134,039.40	89,948.75
76	3.1.01.2.1.1.9.02 Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,440.90	4,165.60
<b>77</b>	<b>3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>58,274.20</b>	<b>1,888,157.70</b>
78	3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг	5,000.000	1,842,034.70
79	3.1.01.2.1.4.1.01 Засгийн газрын дотоод шилжүүлэг	5,000.00	3,090.00
80	3.1.01.2.1.4.1.03 Төсвийн санхүүжилт	0.00	1,838,944.70
81	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	53,274.20	46,123.00
82	3.1.01.2.1.4.2.04 Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36,960.00	36,960.00
83	3.1.01.2.1.4.2.07 Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	7,314.20	7,278.00
84	3.1.01.2.1.4.2.08 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,000.00	1,885.00
<b>85</b>	<b>3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,112,324.90</b>	<b>874,187.53</b>
86	3.1.01.2.2.4 Бусад хөрөнгө	1,112,324.90	874,187.53
<b>87</b>	<b>3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>100,000.00</b>	<b>0.00</b>
88	3.1.01.2.3.1 Эргэж төлөгдөх зээл	100,000.00	0.00
<b>89</b>	<b>3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>-1,941,944.70</b>	<b>-2,225,600.42</b>
<b>90</b>	<b>3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,941,944.70</b>	<b>2,225,600.42</b>
<b>91</b>	<b>3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт</b>	<b>1,941,944.70</b>	<b>2,225,600.42</b>
92	4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	1,970,475.86
93	5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	1,583,820.15

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Мянган төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	1. Тайлант он
<b>1</b>	<b>1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>948,424.38</b>
<b>12</b>	<b>1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>948,424.38</b>
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	948,424.38
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	948,424.38
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	948,424.38
350014	1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	41,777.67
350015	1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	906,646.71
<b>II</b>	<b>1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>820,809.37</b>
<b>21</b>	<b>1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>820,809.37</b>
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	820,809.37
2106	1.1.1.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	20,000.00
210604	1.1.1.2.1.1.6.4 Урсгал засвар	20,000.00
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,444.62
210801	1.1.1.2.1.1.8.1 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	23,444.62
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	777,364.75
210901	1.1.1.2.1.1.9.1 Бараа үйлчилгээний бусад зардал	777,364.75
<b>4</b>	<b>1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>127,615.01</b>
<b>5</b>	<b>1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>(127,615.01)</b>
<b>6</b>	<b>1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт</b>	<b>(127,615.01)</b>

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

#### 3.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил, шийдвэрлэлт.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 84,214.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 22,014.9 мянган төгрөгийн 1 алдааг санхүүгийн тайланд залруулж, 53,723.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага, 8,475.4 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж хүргүүлэв. Залруулсан алдаа:

1. Замд яваа мөнгөн хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаагүй орхигдуулсан 22,014.9 мянган төгрөгийн алдааг аудитын явцад санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулзав;

##### 3.1.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

##### 3.1.2 Албан шаардлага

- 1 Төрийн сангийн ерөнхий орлогын 18,480.9 мянган төгрөг, ОНХС-ийн 6,718.3 мянган төгрөг, ХХС-ийн 3,332.0 мянган төгрөг зэрэг нийт 28,531.2 мянган төгрөгийн урьд оны үлдэгдлийг зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрт тусган төлөвлөөгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", 57 дугаар зүйлийн 57.3-т "Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна" гэсэн заалт;
- 2 Сумын ИТХ-аар баталсан Засаг даргын тамгын газрын санхүүжилтийг 25,192.5 мянган төгрөгөөр илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8-д "төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох." гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

##### 3.1.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал:

**Илрүүлэлт:** Татварын орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь авч үзэхэд Хөрөнгө борлуулсаны орлого, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, бууны албан татвар, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, торгуулийн орлого зэрэг нийт 5 нэр төрлийн татварын орлогыг 8,485.4 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1. "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Татварын орлогыг үндэслэлтэй төлөвлөж, биелэлтэд хяналт тавин нэр төрөл бүрээр бүрэн төвлөрүүлж ажиллах.

Зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг

аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.” гэсэн заалтын дагуу төлөвлөгөөг 1 сарын дотор, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр ирүүлэх.

### **3.2 Тус сумын харьяа орон нутгийн болон улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил, шийдвэрлэлт**

Батширээт сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн төсвийн 2 байгууллага, 1 төрийн сан, 3 тусгай сан, улсын төсвийн 4 байгууллагын тогтмол зардал, ОНӨААТҮГ 2 нийт 12 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагад санал дүгнэлт гаргаж 9 байгууллагын санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулж үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэв.

Аудитад хамрагдсан Засаг даргын тамгын газарт аймаг дахь Төрийн аудитын газар аудит хийж “Хязгаарлалттай” дүгнэлт, Хүүхдийн цэцэрлэг, ЕБС-д “Ари фاینэнс аудит” ХХК аудит хийж тус тус “Өөрчлөлтгүй” дүгнэлт гаргасан байна.

#### **3.2.1 Орон нутгийн байгууллагуудад илэрсэн алдаа зөрчил, шийдвэрлэлт**

Орон нутгийн төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 304,746.4 мянган төгрөгийн 9 алдаа, зөрчил илэрснээс 85,444.6 мянган төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 11,220.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 208,081.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 6 албан шаардлага хүргүүлсэн байна. Үүнд:

##### ***Иргэдийн төлөөлөгчдийн хурал:***

✓ Зөрчил илрээгүй.

##### ***Хоршоо хөгжүүлэх сан:***

✓ Зөрчил илрээгүй.

##### ***Сум дундын ойн анги:***

✓ Зөрчил илрээгүй.

##### ***Засаг даргын тамгын газар:***

✓ Аудитаар нийт 149,624.2 мянган төгрөгийн 5 алдаа, зөрчил илэрснээс 85,444.6 мянган төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 11,220.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 52,959.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлсэн байна.

##### ***Орон нутгийн хөгжлийн сан:***

✓ Аудитаар нийт 13,632.5 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн байна.

##### ***Тохижилт ОНӨААТҮГ:***

✓ Аудитаар нийт 141,489.7 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлаг хүргүүлсэн байна.

#### **3.2.2 Улсын төсвийн байгууллагуудад илэрсэн алдаа зөрчил, шийдвэрлэлт**

Аудитаар нийт 35,509.1 мянган төгрөгийн 12 алдаа, зөрчил илэрснээс 22,223.9 мянган төгрөгийн 5 алдааг аудитын явцад залруулж, 594.8 мянган төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 12,690.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлсэн байна. Үүнд:

**Соёлын төв:**

- ✓ Алдаа зөрчил илрээгүй байна.

**ЕБ-ийн сургууль:**

- ✓ Аудитаар нийт 12,900.3 мянган төгрөгийн 4 алдаа, зөрчил илэрснээс 209.9 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 12,690.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага хүргүүлсэн байна.

**Хүүхдийн цэцэрлэг:**

- ✓ Аудитаар нийт 5,266.9 мянган төгрөгийн 6 алдаа, зөрчил илэрснээс 4,882.0 мянган төгрөгийн 3 алдааг аудитын явцад залруулж, 384.9 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн байна.

**Эрүүл мэндийн төв:**

- ✓ Аудитаар нийт 17,341.9 мянган төгрөгийн 2 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгалгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруул аагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Засаг дарга	1	22,014.9	1	22,014.9			1	22,014.9		
ЗДТГ	2	85,444.6	1	5,444.6	1	80,000.0	2	85,444.6		
ИТХ	-	-								
ОНХС	-	-								
ХХС	-	-								
Сум дундын ойн анги										
Тохижилт үйлчилгээ	-	-								
<b>Орон нутаг дүн</b>	<b>2</b>	<b>85,444.6</b>	<b>1</b>	<b>5,444.6</b>	<b>1</b>	<b>80,000.0</b>	<b>2</b>	<b>85,444.6</b>	-	-
ЕБС	-	-								
СӨБ	3	4,882.0			3	4,882.0	3	4,882.0		
Соёлын төв	-	-								
ЭМТ	2	17,341.9	2	17,341.9			2	17,341.9		
<b>Улсын төсөв дүн</b>	<b>5</b>	<b>22,223.9</b>	<b>2</b>	<b>17,341.9</b>	<b>3</b>	<b>4,882.0</b>	<b>5</b>	<b>22,223.9</b>		
<b>Нийт дүн</b>	<b>8</b>	<b>129,683.4</b>	<b>4</b>	<b>44,801.4</b>	<b>4</b>	<b>84,882.0</b>	<b>8</b>	<b>129,683.4</b>	-	-

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Засаг дарга дүн</b>	<b>3</b>	<b>62,199.1</b>			<b>2</b>	<b>53,723.7</b>	<b>1</b>	<b>8,475.4</b>
ЗДТГ	3	64,179.6	1	11,220.0	2	52,959.6		
ИТХ	-	-						
ОНХС	1	13,632.5			1	13,632.5		
ХХС	-	-						
Сум дундын ойн анги	-	-	-	-	-	-	-	-
Тохижилт ОНӨААҮГ	3	141,489.7			3	141,489.7	-	-
<b>Орон нутаг дүн</b>	<b>7</b>	<b>219,301.8</b>	<b>1</b>	<b>11,220.0</b>	<b>6</b>	<b>208,081.8</b>	-	-
ЕБС	4	12,900.3	1	209.9	3	12,690.4		
СӨБ	3	384.9	1	384.9	1	-	1	-
Соёлын төв	-	-	-	-	-	-	-	-
ЭМТ	-	-	-	-	-	-	-	-
<b>Улсын төсөв дүн</b>	<b>7</b>	<b>13,285.2</b>	<b>2</b>	<b>594.8</b>	<b>4</b>	<b>12,690.4</b>	<b>1</b>	<b>-</b>
<b>Нийт дүн</b>	<b>17</b>	<b>294,786.1</b>	<b>3</b>	<b>11,814.8</b>	<b>12</b>	<b>274,495.9</b>	<b>2</b>	<b>8,475.4</b>

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
<b>Дүн</b>								
<b>Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
<b>Дүн</b>								



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25

Дугаар 278-А2370449  
ХЭА-2026/005/НА-СТА-ТТЗ

Чингис хот

Г Зөрчил таслан зогсоох тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Батширээт сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн сангийн ерөнхий орлогын 18,480,864.00 (арван найман сая дөрвөн зуун наян мянга найман зуун жаран дөрөв) төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн 6,718,268.00 (зургаан сая долоон зуун арван найман мянга хоёр зуун жаран найм) төгрөг, Хоршоо хөгжүүлэх сангийн 3,332,031.00 (гурван сая гурван зуун мянга гучин нэг) төгрөг, нийт 28,531,163.00 (хорин найман мянга таван зуун гучин нэгэн мянга нэг зуун жаран гурав) төгрөгийн урьд оны үлдэгдлийг зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрт тусган төлөвлөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", 57 дугаар зүйлийн 57.3-т "Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.5-д "төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг санхүүжүүлэх эх үүсвэрт урьд оны үлдэгдлийг бүрэн төлөвлөдөггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга Б.Алтангэрэлд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Х.ЕРКЕГҮЛ



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 03 сарын 25

Дугаар 279-А/2370449  
ХЭА-2026/005/НА-СТА-ТТЗ Чингис хот

Г Зөрчлийг таслан зогсоох тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Батширээт сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын ИТХ-аар баталсан Засаг даргын тамгын газрын санхүүжилтийг 25,192,525.00 (хорин таван сая нэг зуун ерэн хоёр мянга таван зуун хорин тав) төгрөгөөр илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8-д "төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.5-д "төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олгодоггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг дарга Б.Алтангэрэл-д даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР



Ж.ГАНБААТАР  
Х.ЕРКЕГҮЛ